БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 30 өдөр Дугаар А/618 Булган сум

Зам гүүрийн засварын ажилд
хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 21.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны XII/21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Бугат сумын Найрамдал багийн зам гүүрийн засварын ажилд шаардагдах 29,000,000 (хорин есөн сая) төгрөгийг Байгаль хамгаалах сангийн Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

2.Дээрх зам гүүрийн засварын ажлыг шуурхай, чанартай гүйцэтгэж, зорчих хөдөлгөөнийг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг Бугат сумын Засаг дарга (Х.Уганбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж